



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/201

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.17 дахь заалт, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төв болон олон улсын "Вирту сан" ашгийн бус байгууллага хооронд 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан Хамтран ажиллах харилцан ойлголцлын гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 10 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг бичиж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080654



МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
 ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
 ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харъяалал	Ажиллах байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөр лийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Элахи Эбрахим Elahi Ebrahim	Америкийн Нэгдсэн Улс	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	ГЭ0001710	Нүд судлал	Эмчлэх	2017-05-19 2017-05-28 10 хоног
2.	Шохэт Майкл Роберт Shohet Michael Robert	Америкийн Нэгдсэн Улс	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	ГЭ0001711	Толгой хүзүүний мэс засал судлал	Эмчлэх	2017-05-19 2017-05-28 10 хоног
3.	Шохет Жэц А Shohet Jack A	Америкийн Нэгдсэн Улс	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	ГЭ0001712	Чих, хамар хоолой судлал	Эмчлэх	2017-05-19 2017-05-28 10 хоног
4.	Ганди Параг Gandhi Parag	Америкийн Нэгдсэн Улс	Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Ховд аймгийн Бүсийн Оношилгоо, эмчилгээний төв	ГЭ0001713	Нүд судлал /нөхөн сэргээх пластик мэс засал судлал/	Эмчлэх	2017-05-19 2017-05-28 10 хоног
5.	Жофрой Лаурент Мишел Пиер Jouffroy Laurent Michel Pierre	Бүгд Найрамдах Франц Улс	Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Ховд аймгийн Бүсийн Оношилгоо, эмчилгээний төв	ГЭ0001714	Мэдээгүйжүүлэг судлал	Эмчлэх	2017-05-19 2017-05-28 10 хоног

6.	Фремфон Тамиеша А Fremping Tamiesha A	Америкийн Нэгдсэн Улс	Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Ховд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	ГЭ0001715	Хүүхдийн нүд судлал	Эмчлэх	2017-05-19 2017-05-28 10 хоног
7.	Коул Чарлес Акерсон Cole Charles Ackerson	Америкийн Нэгдсэн Улс	Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Ховд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	ГЭ0001716	Нүд судлал	Эмчлэх	2017-05-19 2017-05-28 10 хоног
8.	Реза Яссари Yassari Reza	Бүгд Найрамдах Австри Улс	Улсын гуравдугаар төв эмнэлэг	ГЭ0001717	Нурууны мэс засал судлал	Эмчлэх	2017-05-19 2017-05-28 10 хоног
9.	Абрамович Аполония Элизабет Abramowicz Apolonia Elisabeth	Америкийн Нэгдсэн Улс	Улсын гуравдугаар төв эмнэлэг	ГЭ0001718	Мэдээгүйжүүлэг судлал	Эмчлэх	2017-05-19 2017-05-28 10 хоног
10.	Алон Эран Эмануэл Alon Eran Emanuel	Америкийн Нэгдсэн Улс	Хавдар судлалын үндэсний төв	ГЭ0001719	Толгой, хүзүүний мэс засал судлал	Эмчлэх	2017-05-19 2017-05-28 10 хоног